



ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2025 оны 09 сарын 09 өдөр

Дугаар 1/62

Улаанбаатар хот

Тохиолдлын удирдлагын тогтолцоогоор ажиллуулах тухай

Монгол Улсын Шадар сайдын 2023 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 28 дугаарыг тушаалыг үндэслэн ТУШААХ нь:

1.Хөвсгөл аймгийн Мөрөн, Цагаан-Уул сумдад тарваган тахал өвчний хүний өвчлөлийн тохиолдол бүртгэгдэж, тархвар судлалын байдал хүндэрч, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал үүсч болзошгүй учир төвийн холбогдох нэгж, албан тушаалтныг тохиолдлын удирдлагын тогтолцоонд шилжүүлсүгэй.

2.Тохиолдлын удирдлагын тогтолцооны баг бүрэлдэхүүнийг нэгдүгээр, чиг үүргийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Тохиолдлын удирдлагын тогтолцооны бие бүрэлдэхүүнийг удирдлагаар хангах, төлөвлөгөө батлуулах, нэгдсэн тайлан гаргахыг Тохиолдлын удирдлагын тогтолцооны Зохицуулагч (У.Нямжаргал)-д үүрэг болгосугай

4.Тохиолдлын удирдлагын тогтолцоогоор ажиллах хугацаанд шаардагдах зардлын тооцоолол хийж, шаардлагтай төсөв хөрөнгийг холбогдох зардлаас гаргахыг Ерөнхий нягтлан бодогч (Д.Болормаа)-д зөвшөөрсүгэй.

5.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Чанар, аюулгүй байдал, хяналт-үнэлгээний албаны дарга (Б.Ичинхорол)-д даалгасугай.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ

БАМГАЛАНБАЯР



Заснолын өвчин судлалын үндэсний төвийн
Захирлын албан үүргийг хавсран гүйцэтгэгчийн
2025 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн
17.62 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



ТОХИОЛДЛЫН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦООНЫ БАГ БҮРЭЛДЭХҮҮН

Тохиолдлын удирдлагын тогтолцооны

Зохицуулагч: У.Нямжаргал

(Захиргааны албаны дарга)

Дэд зохицуулагч: Х.Ариунболд

(Нийгмийн эрүүл мэнд, тандалт,
шуурхай удирдлагын албаны дарга)

Төлөвлөлт, тархвар зүйн баг:

Ахлагч: Б.Уянга

(Төсөл, хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд: Б.Ичинхорол

(Чанар, аюулгүй байдал, хяналт-
үнэлгээний албаны дарга)

Б.Байгалмаа

(Вирусологич-Лабораторийн чанарын менежер)

Н.Саруулчулуун

(Халдвар судлагч)

Ч.Буянхишиг

(Клиникийн их эмч)

Э.Пагмадулам

(Хүний нөөцийн менежер)

Г.Лхагвасүрэн

(Архив, бичиг хэргийн ажилтан)

Шуурхай хариу арга хэмжээний баг:

Шуурхай хариу арга хэмжээний 1-р баг (Голомтод ажиллах)

Ахлагч: Х.Ариунболд

(Нийгмийн эрүүл мэнд, тандалт,
шуурхай удирдлагын албаны дарга)

Л.Роломжав

(Халдвар судлагч)

Н.Даваажав

(Эсийн генетикч)

О.Эрдэнэцэцэг

(Нян судлаач)

Х.Мөнхтуул

(Нян судлаач)

Д.Отгонсүрэн

(Лаборант)

Ц.Бат-Өлзий

(Лаборант)

Ш.Энхтуяа

(Ариутгагч)

Д.Жамъянсүрэн

(Түргэн тусламжийн жолооч)

Ч.Лхагвасүрэн

(Түргэн тусламжийн жолооч)

Шуурхай хариу арга хэмжээний 2-р баг (Төвд ажиллах)

Ахлагч: Ц.Отгонцэцэг

(Халдвар судлагч)

Ц.Хишигжаргал

(Ариутгал, халдваргүйтгэл,

биоүйлдвэрлэлийн албаны дарга)

А.Бямбахишиг

(Халдвар судлагч)

Г.Зулцэцэг

(Халдвар судлагч)

Б.Алтантуяа

(Нян судлаач)

Я.Сарнай

(Эсийн генетикч)

Ч.Буянхишиг

(Лаборант)

Б.Лхагвабаяр

(Лаборант)

Б.Алтансүх
Б.Пүрэв-Очир

(Түргэн тусламжийн жолооч)
(Түргэн тусламжийн жолооч)

Эрсдэлийн харилцаа холбооны баг:

Ахлагч: Д.Алтантогтох

(Эрдэм шинжилгээ, сургалт, мэдээлэл
технологийн албаны дарга)

Э.Очиржамаа

(Чанарын менежер)

Ц.Ганхуяг

(Амьтан судлаач)

М.Даваадорж

(Амьтан судлаач)

Т.Анарсүрэн

(Тоног төхөөрөмжийн инженер)

Х.Бурмаа

(Статистикч)

Нөөц, санхүүгийн баг:

Ахлагч: Д.Болормаа

(Ерөнхий нягтлан бодогч)

Д.Болдбаатар

(Нөөцийн агуулахын эрхлэгч)

Б.Номин-Эрдэнэ

(Эдийн засагч)

Ц.Дарьсүрэн

(Тооцооны нягтлан бодогч)

Р.Мөнх-Ургамал

(Эм зүйч-Чанарын менежер)

Т.Батцэнгэл

(Түргэн тусламжийн жолооч)

Я.Норовцэрэн

(Түргэн тусламжийн жолооч)

Зарлан дуудагч: Ч.Бат-Ирээдүй

(Халдвар судлагч)

Аюулгүй байдал хариуцсан

ажилтан: П.Лхагвацэрэн

(Хөдөлмөрийн аюулгүй байдал,
эрсдэл хариуцсан мэргэжилтэн)

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн
Захирлын албан үүргийг хавсран гүйцэтгэгчийн
2025 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн
17.62 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

9025090550
9092005-4 CFT30424

ТОХИОЛДЛЫН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦООНЫ БАГ БҮРЭЛДЭХҮҮНИЙ ЧИГ ҮҮРЭГ

Зохицуулагчийн чиг үүрэг:

- Тохиолдлын удирдлагын тогтолцооны бүрэлдэхүүнийг удирдлагаар хангах, өдөр тутмын шуурхай хуралдааныг зохион байгуулах, тохиолдлын удирдлагын тогтолцооны нэгдсэн тайланг баталгаажуулах
- Тохиолдлын удирдлагын тогтолцоог идэвхижүүлэх, уг шийдвэрийг цуцлах, бие бүрэлдэхүүнийг өргөжүүлэх, багасгах шийвэр гаргах
- Үүссэн нөхцөл байдалтай холбоотой мэдээллээр удирдах дээд байгууллага, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Улсын онцгой комисс гэх мэт холбогдох байгууллагуудыг албан ёсны, үнэн зөв мэдээллээр хангах
- Мэдээлэл, сургалт сурталчилгааны материалыг олон нийтэд түгээх зөвшөөрөл олгох, мэдээлэл өгөх, шаардлагатай зардлыг төлөвлөх, хяналт тавих
- Зарлан дуудагч болон аюулгүй байдал хариуцсан ажилтныг өдөр тутмын шууд удирдлагаар хангах

Дэд зохицуулагчийн чиг үүрэг:

- Үүссэн нөхцөл байдал, хариу арга хэмжээний явц үр дүнгийн талаарх албан ёсны мэдэгдлийг хянан, баталгаажуулах
- Зохицуулагчийн эзгүйд чиг үүргийг гүйцэтгэх
- Тохиолдлын удирдлагын тогтолцоонд орж ажиллаж байгаа бие бүрэлдэхүүний өдөр тутмын үйл ажиллагааг зохицуулах
- Багуудын үйл ажиллагааны үр дүнг нэгтгэн, зохицуулагчид танилцуулж, зохих шийдвэр гаргуулах
- Бүх багуудын мэдээллийн агуулгыг хянан, баталгаажуулах

Төлөвлөлт, тархвар зүйн багийн чиг үүрэг:

- Хариу арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөөг шуурхай боловсруулан, батлуулж, тогтмол тодотгол хийх
- Төлөвлөлт хийхэд шаардлагатай мэргэжлийн чиглэлийн бүх мэдээллийг ШУН-аар дамжуулан авч, мэдээлэлд түргэвчилсэн эрсдлийн үнэлгээ хийх
- Өдөр тутмын шинэчлэгдсэн мэдээллийг бэлтгэн, хянуулах, бүх төрлийн мэдээллийг цуглуулах, дүн шинжилгээ хийх, хэтийн төлөвийг тооцоолох
- Хариу арга хэмжээний чиглэл, цар хүрээ, шаардагдах нөөцийг төлөвлөх, шаардлагатай заавар, журам, албан даалгавар зэрэг бодлогын болон техникийн баримт бичгийг боловсруулах, батлуулах
- Тохиолдлын удирдлагын тогтолцооны бие бүрэлдэхүүний болон хариу арга хэмжээг зохион байгуулахад шаардлагатай хүний нөөцийг дайчлан ажиллуулах, ажлын цагийн хуваарь боловсруулан батлуулах, цагийн тооцоо хийх

Шуурхай хариу арга хэмжээний багийн чиг үүрэг:

- Төлөвлөлтийн багаас боловсруулсан хариу арга хэмжээний төлөвлөгөөний өдөр тутмын хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих
- Мэргэжлийн болон бусад байгууллагуудыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах
- Дайчлагдан ажиллаж буй бие бүрэлдэхүүний эрүүл мэндийн байдлыг хянах
- Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал үүссэн голомтод ажиллах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх
- Төлөвлөлтийн багийг өдөр тутмын мэдээллээр хангах

Эрсдлийн харилцаа холбооны багийн чиг үүрэг:

- Үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан олон нийтэд түгээх анхны мэдэгдлийн төсөл боловсруулах, шинэчилсэн мэдээлэл бэлтгэх, хүн амыг мэдээллээр тогтмол хангах
- Зорилтот бүлгийн хүн амыг тогтоох, мэдээллийн хэрэгцээг тодорхойлох, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийг үнэн зөв, бодитой мэдээллээр тогтмол хангах
- Хүн амд чиглэсэн сэрэмжлүүлэг, зөвлөмж, сургалт сурталчилгааны материалын эхийг боловсруулах, түгээх
- Хэвлэлийн бага хурал зохион байгуулах
- Хариу арга хэмжээний үед ашигласан мэдээлэл, сургалт сурталчилгааны материалыг цахим болон цаасан хэлбэрээр хадгалах, архивлах

Нөөц, санхүүгийн багийн чиг үүрэг:

- Хариу арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн болон техник тоног төхөөрөмжийн нөөцийг бүрдүүлэх, хуваарилах, зарцуулалтад хяналт тавих
- Шаардлагатай тохиолдолд халдварт өвчний болон гамшгийн нөөцийг дайчлах
- Тохиолдлыг удирдлагын тогтолцооны бие бүрэлдэхүүнд ажиллаж буй ажилтнуудын цагийн тооцоо, бүртгэлийн дагуу цалинг олгох
- Багуудын үйл ажиллагааг хэвийн явуулах байр, техник тоног төхөөрөмж, дэд бүтцээр хангах
- Өдөр тутмын санхүүгийн тайлан гаргах, танилцуулах

Зарлан дуудагчийн чиг үүрэг:

- Эрсдлийн төрөл хэлбэрээс хамааран Зохицуулагч, Дэд зохицуулагч болон бусад багуудыг дуудах, цуглуулах ажлыг зохион байгуулах, хариу арга хэмжээг хэрэгжүүлэх явцад нэмэлтээр дуудах шаардлагатай бие бүрэлдэхүүнийг зарлан цуглуулах
- Шуурхай удирдлагын нэгжийн үйл ажиллагааг зохицуулах
- Шуурхай удирдлагын нэгжийн аюулгүй байдлыг хангах

Аюулгүй байдал хариуцсан ажилны чиг үүрэг:

- Тохиолдлын удирдлагын тогтолцооны бие бүрэлдэхүүнийг ажлын бус цагаар ажиллахад хүргэх, авах, хоол хүнс, ажил амралтыг зохицуулах
- Тохиолдлын удирдлагын тогтолцооны бие бүрэлдэхүүнийг альваа эрсдэлд өртөхөөс сэргийлэх, аюулгүй ажиллагааны зааварчилгаагаар хангах
- Өртөлтийн өмнөх болон дараах урьдчилан сэргийлэлтэд хамруулах, эрүүл мэндийг хянах ажлыг гардан зохион байгуулах